



СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 06 сарын 05 өдөр


Дугаар 50

Сүхбаатар сум

Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1, 28 дугаар зүйлийн 28.1, Гэр бүлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, 26 дугаар зүйлийн 26.1, 26.2.1, 26.2.4, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.4, 3 дугаар зүйлийн 3.3, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 5.3, 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.2, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 15.6 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

- 1."Жаргалтай гэр бүл" аймгийн хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.
- 2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, нэгдсэн удирдлагаар хангах, хөтөлбөрийн явцыг 2 жил тутамд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг дарга /Ш.Оргил/-д даалгасугай.



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2018 оны 06 дугаар сарын
05-ны өдрийн 50 дугаар тогтоолын хавсралт-1

“ЖАРГАЛТАЙ ГЭР БҮЛ” АЙМГИЙН ХӨТӨЛБӨР

446 9055363

Хөтөлбөрийн хэрэгцээ шаардлага

Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого, Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр, Засгийн газрын болон Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг баримт бичигт гэр бүлийн хөгжил, үнэ цэнэ, нийгмийн хамгааллын талаар тусгасан.

Гэр бүлийн өнөөгийн байдал, амьдралын хэв маяг гарч буюу өөрчлөлт хандлагыг дагаж, гэр бүл салалт, өрх толгойлсон эмэгтэйчүүд, амьжиргаагаа дээшлүүлэхийн тулд гадаадад хөдөлмөр эрхлэх залуучууд, гэр бүлийн халуун дулаан орчинд өсөж торних боломжгүй хүүхдийн тоо нэмэгдсээр байна.

Аймгийн хэмжээнд суурин хүн ам 2017 оны байдлаар 108768 хүрч, өмнөх оныхоос 1,9 хувиар, нийт өрхийн тоо 29912 буюу өмнөх оноос 0,5 хувиар өссөн байна. Нийт хүн амын 55067 буюу 50,6 хувь нь эрэгтэйчүүд, 53701 буюу 49.4 хувь нь эмэгтэйчүүд, 31657 буюу 29,1 хувь нь 0-14 насны хүүхэд 69546 буюу 63.9 хувь нь 15-59 насныхан, 7565 буюу 7.0 хувийг 60 -аас дээш насныхан эзэлж байна.

2017 оны байдлаар аймгийн хэмжээнд 566 хүн гэрлэлтээ батлуулж, 141 хүн гэрлэлтээ цуцлуулж, 57 хүүхэд үрчлэгдэж, хагас өнчин хүүхэд 1456, бүтэн өнчин хүүхэд 143 бүртгэгдсэн. Өрх толгойлсон 4112 хүн байгаа ба үүнээс 2786 нь гурав хүртэлх хүүхэдтэй өрх байна.

Гэр бүлийн тогтвортой байдал, гэр бүлийн хөгжлийг дэмжих, зэрэг таатай уур амьсгал бүрдсэн аз жаргалтай гэр бүл бий болгоход “Жаргалтай гэр бүл” хөтөлбөрийг хэрэгжүүлэх бодит хэрэгцээ шаардлага байна.

Нэг. Хөтөлбөрийн зорилго

Нийгмийн оролцоонд гэр бүлийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, амьдралын үнэ цэнийг ойлгуулах, чадамжийг сайжруулах, гэр бүлийн уламжлалт соёл, ёс заншлыг сэргээн хөгжүүлэх, гэр бүлд тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхэд оршино.

Хоёр. Хөтөлбөрийн зорилт

- 2.1. Монгол гэр бүлийн үнэт зүйлсийг бэхжүүлж, нийгэмд өзлэх байр суурь, хувь нэмрийг нэмэгдүүлэх
- 2.2. Хүний өвчин эсэргүүцэх дархлааг нэмэгдүүлэх, бие бялдарын хөгжлийг дэмжиж, эрүүл мэндийн боловсрол олгох
- 2.3. Удам угсаагаа дээдлэх, уламжлалт соёл, ёс заншлыг түгээн дэлгэрүүлэх
- 2.4. Гэр бүлийн эдийн засгийн боловсролыг нэмэгдүүлж, бүтээлч сэтгэлгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих
- 2.5. Гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, аюулгүй орчин бүрдүүлэх

Гурав. Хөтөлбөрийн хамрах хүрээ

- 3.1. Гэр бүлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон иргэний нийгмийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэнийг хамарна.

Дөрөв. Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаа

- 4.1. Хөтөлбөрийг 2 үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- Хөтөлбөрийн нэгдүгээр үе шат 2018-2020 он

- Хөтөлбөрийн хоёрдугаар үе шат 2020- 2022 он

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ

5.1. Монгол гэр бүлийн үнэт зүйлсийг бэхжүүлж, нийгэмд эзлэх байр суурь, хувь нэмрийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:

5.1.1. Гэр бүлийн боловсрол олгох, хандлагыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах

5.1.2. Гэр бүлийн хөгжлийг дэмжих, чөлөөт цагаа үр бүтээлтэй өнгөрүүлэх арга хэмжээг зохион байгуулах

5.1.3. Сар бүрийн нэг өдрийг “Гэр бүлийн өдөр” болгож, гэр бүлийг идэвхжүүлэх, сайн туршлагыг нийтэд сурталчлах ажлыг тогтмол зохион байгуулах

5.1.4. Залуу гэр бүл, 18 хүртэлх насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй гэр бүлийг орон сууцжуулах бодлогыг өргөн хүрээнд дэмжиж хэрэгжүүлэх

5.1.5. Гэр бүлийн харилцааны тогтвортой байдлыг дэмжих “Гэр бүлд зөвлөгөө өгөх алба”-ыг байгууллага бүрт ажиллуулах

5.2. Хүний өвчин эсэргүүцэх дархлааг нэмэгдүүлэх, бие бялдарын хөгжлийг дэмжиж, эрүүл мэндийн боловсрол олгох зорилтын хүрээнд:

5.2.1. Гэр бүлд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндээ хамгаалж, амьдралын эрүүл, зөв хэв маяг, зан үйлийг төлөвшүүлэх

5.2.2. Нийтийн биеийн тамир, спортыг дэмжин дэлгэрүүлэх

5.2.3. Эрүүл мэнд, амьдралын чанарт сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлс агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах

5.2.4. Гэр бүлд эрүүл мэндийн даатгал, чанартай хүртээмжтэй, анхан шатны үйлчилгээг хүргэх

5.2.5. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйг сайжруулж, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах

5.3. Удам угсаагаа дээдлэх, уламжлалт соёл, ёс заншлыг түгээн дэлгэрүүлэх зорилтын хүрээнд:

5.3.1. Угийн бичиг хөтлөх, удмын санд учирч болзошгүй сөрөг нөлөөллийг арилгах, урьдчилан сэргийлэх

5.3.2. Монгол уламжлалт ёс заншлыг сэргээн, гэр бүлийн эерэг хандлагыг нэмэгдүүлэх чиглэлийн арга хэмжээг зохион байгуулах, сурталчлах

5.4. Гэр бүлийн эдийн засгийн боловсролыг нэмэгдүүлж, бүтээлч сэтгэлгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилтын хүрээнд:

5.4.1. Гэр бүлийн санхүүгийн хуримтлал үүсгэх, эдийн засгийн эрсдлийг даван туулах мэдлэг чадварт суралцахад дэмжих

5.4.2. Гэр бүлийн бизнес, өрхийн үйлдвэрлэл тогтвортой эрхлэх, санхүү эдийн засаг, эрх зүйн нөхцлийг хангах

5.4.3. Бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх бүх талын арга хэмжээ авах, дэмжих, сурталчлах

5.4.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх

5.5. Гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, аюулгүй орчин бүрдүүлэх зорилтын хүрээнд:

5.5.1. Гэр бүлийн хүчирхийллийг бууруулах “Гэрээр айлчлах” аргачлалыг хэрэгжүүлэх

5.5.2. Гэр бүлд зөв зан үйл, хандлагыг төлөвшүүлэх, хууль эрх зүйн мэдлэг олгох нөлөөллийн ажлыг зохион байгуулах

5.5.3. Болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, архи, мансууруулах бодис, хорт зуршлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх

Зургаа.Хүрэх үр дүн

6.1. Гэр бүлийн боловсрол дээшилж, үнэ цэнэ нэмэгдэнэ.

6.2.Угийн бичиг хөтлөх арга зүйд суралцаж, эрүүл, чийрэг, идэвхитэй, хариуцлагатай, жаргалтай, бат бөх гэр бүлийг төлөвшүүлнэ.

6.3.Гэр бүлийн гишүүдийн нийгэмд оролцох оролцоо, идэвх санаачлага нэмэгдэнэ.

Долоо.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилт

7.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлэх.

7.2.Гадаад, дотоодын төсөл хөтөлбөрөөс олгох тусламж, дэмжлэг.

Найм.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэрэгжилтийг тайлagnах /хяналт шинжилгээ үнэлгээ/

8.1.Гэр бүлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон иргэний нийгмийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдтэй хамтран ажиллана.

8.2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, шаардлагатай төсвийг жил бүр боловсруулан батлуулж, мэргэжил, арга зүй, удирдамжаар хангах үүргийг аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар хариуцах бөгөөд хэрэгжилтийн явцыг хагас, бүтэн жилээр аймгийн Засаг даргын зөвлөлд тайлagnана.